



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 16, өдөр

Дугаар 737

Улаанбаатар хот

“Төрийн орон сууцны корпораци”  
төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай  
компанийн дүрэмд нэмэлт оруулах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 59 дүгээр зүйлийн 59.2, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд дараах нэмэлт оруулсугай.

- 1.1. 4.2.13-т “хөрөнгө оруулалтын судалгаа хийх.” гэж;
- 1.2. 4.2.14-т “барилгын ажлын үе шатанд хяналт тавих, барилга байгууламжийн ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргах.” гэж;
- 1.3. 4.2.15-т “төслийн удирдлага, зохион байгуулалт, технологийн түвшин.” гэж;
- 1.4. 4.2.16-т “барилга байгууламжийн захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх.” гэж;

2.“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/-д үүрэг болгосугай..

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ